



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АЛБА

ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН СУДАЛГАА

УЛААНБААТАР ХОТ

2017 он

НЭГ. АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ

Засгийн газраас сүүлийн 20 жилийн хугацаанд “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний дөрвөн хөтөлбөр (1997-2016), “Эхийн эндэгдлийг бууруулах стратеги” (2001-2004, 2005-2010), “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамж стратеги” (2009-2013), “Эх, нярайн эрүүл мэндийн стратеги” (2011-2015), “Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг хэрэгжүүлэх стратеги” (2014-2020), “Нярайн тандалт, шинжилгээний хөтөлбөр” (2014-2020) зэрэг 10 гаруй бодлогын баримт бичгийг хэрэгжүүлсэн. Хөтөлбөр, стратегийг үе шаттай хэрэгжүүлсний үр дүнд 2015 онд эхийн эндэгдлийн харьцаа 26.0, нялхасын эндэгдлийн түвшин 15.3, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 18.3 болж буурснаар хүүхдийн эндэгдлийг 4 дахин бууруулах зорилтыг бүрэн хэрэгжүүлж, эхийн эндэгдэл өндөртэй орноос эхийн эндэгдэл дунд зэрэгтэй орны түвшинд шилжсэн. Ийнхүү ахиц гаргасан хэдий ч эх, хүүхдийн өвчлөл, эндэгдэл тогтвортой буурахгүй, зарим бүс нутаг, аймагт эх, хүүхдийн эндэгдлийн харьцаа өндөр байна.

Хүүхдийн эндэгдэл анхаарал татсан асуудал хэвээр байна. Тав хүртэлх насны хүүхдийн болон нялхсын эндэгдэл нь хот, хөдөө, бүс нутгаар ялгаатай байна. Сүүлийн 5 жилд улсын хэмжээнд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 18.6, хөдөө орон нутагт 20.5 Улаанбаатар хотод 16.8 байна. Хөдөө орон нутагт тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин Улаанбаатар хотоос 3.7 пунктээр илүү, ялангуяа, баруун бүсэд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 24.6 байгаа нь улс, аймгийн дунджаас өндөр байна.

“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 78 дугаар тогтоолоор батлагдсан. Уг тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгааны ажлыг зайлшгүй хийх шаардлага тулгараад байна.

ЗОРИЛГО

Хүүхдэд зориулсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын байдал, зайлшгүй байх ёстой стандартын хангалтыг судлах.

ЗОРИЛТ

1. Хүүхдэд зориулсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн стандартыг судлах;
2. Монгол улсын эрүүл мэндийн салбарт ашиглаж буй хүүхдэд зориулсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээлэл цуглуулах;

ҮР ДҮН

- ✓ Монгол улсын эрүүл мэндийн салбарт ашиглагдаж буй хүүхдэд зориулсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийг стандарттай харьцуулан хангалтыг гаргаж шийдвэр гаргагчдыг нотолгоогоор хангана.
- ✓ Монгол улсын эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж буй хүүхдэд зориулсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгаатай болсон байна.

ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны арга:

Судалгааг тусгайлан бэлтгэсэн маягтын дагуу мэдээлэл цуглуулж, зарим баримт материалтай танилцан баталгаажуулна.

Судалгааны хамрах хүрээ:

- ✓ Эрүүл мэндийн яамны харьяа улсын төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв,
- ✓ Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг
- ✓ Аймгийн эрүүл мэндийн газрын харьяа Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг

Судалгааны хүн хүчин:

- ✓ Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба
- ✓ Эрүүл мэндийн байгууллагын инженер, техникийн ажилтнууд

Мэдээлэл цуглуулах:

- ✓ Судалгааны удирдамж болон маягтын хамт ЭМЯ-ны болон НЭМГ-ын харьяа, аймгийн эрүүл мэндийн байгууллагуудруу Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс албан бичгээр тус тус хүргүүлэх
- ✓ Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын инженер техникийн алба болон эмнэлгийн тоног төхөөрөмжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд нь тусгайлан боловсруулсан асуумжийг бөглөн, цахим шуудангаар илгээх
- ✓ Аймгийн болон нийслэлийн эрүүл мэндийн газар нь харьяа байгууллагуудын мэдээллийг нэгтгэн ирүүлэх
- ✓ Судалгааны ажил эхлэхийн өмнө эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер болон тоног төхөөрөмж хариуцсан мэргэжилтэнд мэдээллийг өгөх

Судалгааны мэдээлэл боловсруулах: Судалгааны асуумжийн дагуу дүн шинжилгээ хийх ба боловсруулалтын явцад тодорхой бус мэдээллийг цахимаар болон утсаар, биечлэн очиж тодруулга хийж, тайлан бичнэ.

ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН СУДАЛГААНЫ АСУУМЖ

1. Хүүхдийн эмчилгээ, оношилгоонд ашиглагдаж буй эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээлэл

Эмнэлгийн нэр:

Хүснэгт 1.

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Үйлдвэрлэсэн улс	Үйлдвэрлэсэн он	Тоо ширхэг	Нэгж үнэ /төгрөг/	Эх үүсвэр			Үйл ажиллагааны өнөөгийн байдал	Баталгаат хугацаан дэх техникийн үзлэг, үйлчилгээний тоо	Засвар үйлчилгээ		Оношилгоо, эмчилгээ хийгдсэн тоо /2016 он/	Цаашид хэвийн ажиллуулахад шаардагдах төсөв	Тайлбар
							Улсын төсөв	Байгууллага /Орон нутаг/-ын хөрөнгө оруулалт	Хандив, тусламж /нэр/			Бусад	Эвдрэл гэмтлийн тоо			
Тасгийн нэр																
	Нийт															

2. Хүүхдийн эмчилгээ, оношилгоонд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээлэл

Эмнэлгийн нэр:

Хүснэгт 2.

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Тайлбар
Тасгийн нэр						
	Эмчилгээний тоног төхөөрөмж					
	Оношилгооны тоног төхөөрөмж					
	Нийт					

Судалгаа хийсэн:

Хянасан:

Судалгаа хийсэн

огноо:

ГУРАВ. ҮР ДҮН

Хүүхдэд зориулсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн хүртээмж багатай, хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалт оновчтой бус, зориулалтын бус эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг ашиглагддаг, тэдгээр тоног төхөөрөмжийн тоо ширхэг цөөхөн зэргээс шалтгаалан хүүхдийн эмчилгээ, оношилгоонд уг тоног төхөөрөмжүүд хангалттай хүрэлцэхгүй болоод байна.

Иймээс эрүүл мэндийн байгууллагуудад ашигладаг хүүхдэд зориулсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын байдал, шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгаа, түүнд шаардлагатай санхүүжилтийг тодорхойлж, шийдвэр гаргагчдыг үнэн зөв бодит мэдээллээр хангаж, цаашид шаардлагатай арга хэмжээ авахад үндэслэл нотолгоо болгох зорилгоор энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ. Энэхүү судалгааны маягтыг 2017 оны 05 сарын 16-ны өдрийн 514 тоот албан бичгээр эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн.

Судалгаанд хүүхдэд зориулан эмчилгээ, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагууд буюу ЭМЯ-ны харьяа байгууллагууд, НЭМГ-ын харьяа байгууллагууд, 21 аймгийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлгүүд хамрагдсан. Судалгааны удирдамжийн дагуу нийслэлийн эрүүл мэндийн газар нь харьяа байгууллагуудын мэдээллийг нэгтгэн ирүүлсэн.

Судалгаанд хамрагдсан байгууллага

Д/д	Байгууллагын ангилал	Тоо ширхэг
1	Клиникийн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн төв	8
2	Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа байгууллагууд	13
3	Амаржих газар	2
4	Аймгийн нэгдсэн эмнэлэг	16
5	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	5
Нийт		43

1. Хүүхдийн эмчилгээ, оношилгоонд ашиглагдаж буй эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоо ширхэг

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Ашиглагдаж буй эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоо ширхэг
1.	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	14
2.	Улсын гуравдугаар төв эмнэлэг	-
3.	Халдварт өвчин судлалын үндэсний төв	-
4.	Гэмтэл согог судлалын үндэсний төв	10
5.	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	805
6.	<u>Арьсны өвчин судлалын үндэсний төв</u>	1
7.	<u>Хүүхдийн төв сувилал</u>	57

8.	Нийслэлийн эрүүл мэндийн газар	327
9.	Архангай аймаг	57
10.	Баян-Өлгий аймаг	34
11.	Баянхонгор аймаг	23
12.	Булган аймаг	17
13.	Говь-Алтай аймаг	18
14.	Говьсүмбэр аймаг	13
15.	Дархан-Уул аймаг	47
16.	Дорноговь аймаг	18
17.	Дорнод аймаг	17
18.	Дундговь аймаг	19
19.	Завхан аймаг	10
20.	Орхон аймаг	36
21.	Өвөрхангай аймаг	10
22.	Өмнөговь аймаг	45
23.	Сэлэнгэ аймаг	16
24.	Сүхбаатар аймаг	20
25.	Төв аймаг	26
26.	Увс аймаг	18
27.	Ховд аймаг	11
28.	Хөвсгөл аймаг	5
29.	Хэнтий аймаг	22
	НИЙТ	1696

2. Хүүхдийн эмчилгээ, оношилгоонд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоо ширхэг, төсөв

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Шаардлагатай ЭТТ-ийн тоо ширхэг	Нийт төсөв /мянган төгрөг/
1.	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	10	146,900,000
2.	Улсын гуравдугаар төв эмнэлэг	20	338,500,000
3.	Халдварт өвчин судлалын үндэсний төв	72	806,000,000
4.	Гэмтэл согог судлалын үндэсний төв	71	224,000,000
5.	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	20	600,000,000
6.	<u>Арьсны өвчин судлалын үндэсний төв</u>	6	9,780,000
7.	<u>Хүүхдийн төв сувилал</u>	63	200,040,000
8.	Нийслэлийн эрүүл мэндийн газар	434	1,709,320,000
9.	Архангай аймаг	30	131,060,000
10.	Баян-Өлгий аймаг	18	258,780,000
11.	Баянхонгор аймаг	62	531,700,000
12.	Булган аймаг	25	236,840,000
13.	Говь-Алтай аймаг	37	260,820,000
14.	Говьсүмбэр аймаг	40	420,540,000
15.	Дархан-Уул аймаг	17	165,180,000

16.	Дорноговь аймаг	19	134,900,000
17.	Дорнод аймаг	35	277,480,000
18.	Дундговь аймаг	14	189,300,000
19.	Завхан аймаг	48	271,940,000
20.	Орхон аймаг	67	457,000,000
21.	Өвөрхангай аймаг	14	178,700,000
22.	Өмнөговь аймаг	48	273,760,000
23.	Сэлэнгэ аймаг	28	317,140,000
24.	Сүхбаатар аймаг	24	164,500,000
25.	Төв аймаг	23	330,780,000
26.	Увс аймаг	23	54,140,000
27.	Ховд аймаг	64	302,640,000
28.	Хэнтий аймаг	25	225,545,000
29.	Хөвсгөл аймаг	31	162,290,000
	НИЙТ	1388	9,310,620,000

Дүгнэлт

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2017 оны 05 сарын 16-ны өдрийн 514 тоот албан бичгээр эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. “Судалгаа явуулах тухай” 514 дугаар албан тоотор эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж буй хүүхдэд зориулсан эмнэлгийн тоног төхөөрөмж, шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж судалгааг нийслэлийн клиникийн нарийн мэргэжлийн 8 төв, дүүргийн эрүүл мэндийн 10 нэгдэл, дүүргийн нэгдсэн 3 эмнэлэг, амаржих 2 газар, аймгийн нэгдсэн эмнэлэг 16, бүсийн оношилгоо эмчилгээний 5 төвийн нийт 43 эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж буй 1696 эмнэлгийн тоног төхөөрөмж болон судалгаагаар шаардлагатай 1388 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмжийг ирүүлсэн.

Судалгаа авах ажиллагаа судалгааны дүнг нэгтгэх, эмнэлгүүдийн судалгааг чанаржуулах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

1. Хүүхдэд зориулан үйл ажиллагаа явуулдаг 43 эрүүл мэндийн байгууллагад ашиглагддаг 1696 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийг авч нэгтгэсэн.
2. Эдгээр эрүүл мэндийн байгууллагад хүүхдэд зориулсан эмчилгээ оношилгоонд шаардлагатай 1388 эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийг авч нэгтгэсэн.

Дээрх эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн судалгаанаас үзэхэд Эрүүл мэндийн салбарын хүүхдэд зориулан эмчилгээ, оношилгоо хийхэд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийг хангахад нийт 9,310,620,000 төгрөгийн төсөв шаардлагатай байна.